



БОГД БАНК

ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ЖИЛИЙН ТАЙЛАН

2024



WWW.BOGDBANK.COM

АГУУЛГА

БИДНИЙ ТУХАЙ

БОГД БАНК ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БОГД БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

ДОТООД АУДИТ

ЭРСДЭЛИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОН БОГД БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БИЗНЕС БАНКНЫ ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН БАНК

ГАДААД ХАРИЛЦАА

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

КОМПЛЕЙНС

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОГД БАНК ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Богд Банк нь 2014 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш орон даяар нийт 16 салбараар дамжуулж, харилцагч нартаа үйл ажиллагаа явуулж, улам өргөжин тэлсээр байгаа ба тэр дундаа жижиг, дунд бизнесийн зээл нь нийт зээлийн багцын талаас илүү хувийг бүрдүүлдэг ба худалдаа, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдийг түлхүү дэмжиж байна. Мөн тус банк нь Монгол Улсын банкны реформын хүрээнд 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлж, олон нийтийн банк болсон анхны банк юм.

Богд банк нь одоогоор нийт 16 салбараар дотооддоо харилцагч үйлчлүүлэгчдэдээ хэрэгцээ шаардлагад тохирсон санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлж, олон нийтэд нээлттэй, үнэ цэн, итгэл түгээгч банк байхыг эрхэмлэн 200 гаруй ажилтнаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль, орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс гадна гадаад, дотоодын төслийн зээлийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг үр ашгийг нэмэгдүүлэн ажилласаар байна. Бид байгаль орчны бодлогын хүрээнд хүний эрх, хөдөлмөрийн эрхийн болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлдэг харилцагчдыг санхүүжүүлэх чиглэл баримталж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь дунд болон өндөр харилцагчдын хувьд үр ашигтай хамтран ажиллах замаар харилцагчийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийг бууруулж ажиллахыг зарчим болгодог.

Банкнаас нэвтрүүлсэн салбартаа анхдагч бүтээгдэхүүн үйлчилгээнээс онцолбол: Харилцагч харилцах дансны дугаараа дураараа сонгох, B-point урамшууллын лоялти оноо, хугацаатай хадгаламжийн хоногийг хугацаагаар сонгох, байгууллагын харилцагч нартаа зориулж corporate gateway үйлчилгээг харилцагч нартаа шинээр нэвтрүүлж, харилцагчийн хэрэгцээ шаардлага, цаг үе, технологийн дэвшлийн хослуулан ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Дэлхийн шилдэг стандарт, туршлага, шинэ үеийн хандлага боломж, технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнийг төдийгүй ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч банк байна.


ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчдынхаа сэтгэл ханамжийг тэнцвэртэй, тогтвортой хангаж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн үзүүлэлтээрээ олон улсын жишигт хүрсэн, харилцааг эрхэмлэсэн, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч, технологид суурилсан банк байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Банкны ажилтан бүр эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэхдээ ИТГЭЛ/TRUST гэсэн монгол, англи үгээр товчлогдон илэрхийлэгдэх эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг цаг ямагт мөрдөж ажиллана.

БОГД БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

**Л.БОЛДХУЯГ**

ТУЗ-ИЙН ДАРГА



Монгол Улсад орчин цагийн банкны салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн Богд банкны 10 жилийн ой, банк санхүүгийн салбартай холбогдсон он жилүүдээ эргэн дурссан, үүнээс хамгийн том нь (Их наядын) банк болж чадсан бахдам амжилтаар үдэж байна.

2024 онд олон улсын банк болон санхүүгийн байгууллагаас нийт 49.07 сая ам долларын урт хугацаат эх үүсвэр шинээр татан төвлөрүүлж, жижиг дунд бизнесийг тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагаа болон хэрэглээг санхүүжүүлэхэд зориулахаар ажиллаж байна.


Бид мөн эх дэлхий, байгаль орчин болон нийгэмд ээлтэй үйл ажиллагаанд манлайлан, нийгмийн хариуцлагаа ухамсарлан олон ажлыг хэрэгжүүлсэн ба хүүхэд залуусын ирээдүйн хөгжил, бие бялдар хүмүүжилд сайнаар нөлөөлөх спорт, хүүхэд залуусд оюуны хөрөнгө оруулалт хийх зорилгоор, соёл урлагаар дамжуулан олон үйл ажиллагааг дэмжин ажиллалаа.

Бид цаашдаа стратегийн түвшинд үйл ажиллагаа улам сайжруулан нээлттэй ил тод байх зарчмаа ямагт баримтлан салбартаа тэргүүлэгч байхын төлөө ажиллах болно.

Банкныхаа өсөлт хөгжилт бүх цаг үед хамт байж, амжилт бүтээлийн оргил рүү хамт тэмүүлж буй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хувьцаа эзэмшигчид, нийт ажилтнууд болон тэдний гэр бүлд талархал илэрхийлье.

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөн үнэт түүхийг бүтээлцсэн, шинэ бүхнийг санаачлан түүчээлсэн, нийгэм эдийн засагтаа үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм банкирууддаа талархал илэрхийлж, 100 жилийн ойн баярын мэнд хүргэхийн ялдамд аз жаргал, амжилт бүтээл, эв нэгдэл, эрүүл энхийг хүсье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

**Г.САРУУЛ**

ТУЗ-ИЙН ГИШҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Юуны өмнө Монгол улсад орчин цагийн банкны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойтой Богд банкны маань 10 жилийн ой давхацсан онцгой жил тохиолоо. Өдгөө 2014 онд Богд цамхагт үйл ажиллагаагаа эхэлж байсан бид өнөөдөр 260 гаруй ажилтан, 19 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа өргөжүүлэн тэлсэн байна. Богд банк нь өнгөрсөн онд хийж бүтээсэн хамтран ажилладаг түнш байгууллага, харилцагч болон хувьцаа эзэмшигч нартаа 2024 оны онцлох ажлын тайлангаа танилцуулж байгаадаа таатай байна.

Богд банк 2024 жилийн эцсээр татварын дараах цэвэр ашиг 40.16 тэрбум төгрөгт хүрч, өмнөх жилээс 42.43%-аар өссөн. Тайлант хугацааны өөрийн хөрөнгийн өгөөж (annualized ROE) 26%, нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг (EPS) 32.13 төгрөгтэй хаагдлаа.

Бидний ажлын хамгийн чухал үзүүлэлтээс дурдвал нийт хөрөнгө 2024.12.31-ний байдлаар 1,066,504.49 сая төгрөгт/1 их наяд 66 сая төгрөгт/хүрч өмнөх жилээс 49.72%-аар өссөн байна. Цэвэр зээлийн багц 2024.12.31 гэхэд 578.15 тэрбумд хүрч өмнөх жилээс 85.21%-аар өссөн байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь буурч 2.23%-тай болсон байна. Харилцах хадгаламж өмнөх оны мөн үеэс 55.70%-аар өсөж 581.32 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант хугацаанд Богд банк нь Банкны тухай хуулиар болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

2024 онд шинээр 3 салбар буюу Хан-Уул дүүргийн харилцагч нартаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам ойртуулах зорилгоор “Прайм”, “Оргил” болон “Ривер” салбаруудыг нээж, үйл ажиллагаагаа өргөжүүллээ.

Богд банк нь шинэ үеийн төлөөлөл болох хүүхэд багачуудын сонирхдог Esport-оор дамжуулан “Хуримтлалыг бий болгох” болон “Мөнгөний зохистой хэрэглээг” нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсад 1 сая таталттай MOBILE LEGENDS: BANG BANG тоглоомтой хамтран хүүхдэд зориулсан цоо шинэ “Mobile Legends: Bang Bang төлбөрийн карт”-ын бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ.





Банк нь иргэдийн харилцагчийн цаг хугацааг хэмнэх зорилгоор бүхий л төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дижитал руу шилжүүлж байгаа ба үүнээс бид 2024 онд “Bogd Mobile” апп-р дамжуулан зайнаас харилцагч болох үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн.

Банк нь иргэд болон байгууллагын харилцагчдын Бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөрөнгө оруулалтын зээл болон Онлайн КҮБ-ын орлого барьцаалсан зээлийн хугацааг сунгаж, уян хатан нөхцөлтэй болголоо.


Богд банк нь харилцагчдадаа зориулан Хятад улсын нутаг дэвсгэрт Богд банкны Алтан болон Энгийн ЮнионПэй картаараа төлбөр тооцоогоо хийсэн харилцагч бүрт 5%-ийн буцаан олголт олгох урамшууллыг зарласан амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

Салбартаа үргэлж шинийг санаачилж, байгууллагынхаа төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэдэг нийт ажилтнууд, тэдний гэр бүл болон богд банкны хамт олны хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрийг үнэлж, өндөр өсөлт, хурдацтай ахиц дэвшилд итгэл үзүүлэн хөрөнгө оруулсан нийт хувьцаа эзэмшигчдэдээ гүнээ талархал илэрхийлье.


 ТУЗ-ИЙН ГИШҮҮД



 ЕРӨНХИЙ АУДИТОР



 ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ




ДОТООД АУДИТ

Банкны дотоод аудитын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяанд байх. Дотоод аудитын газар хариуцан ажилладаг. Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг бие даасан, бодитойгоор үзүүлж байна. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Гүйцэтгэх удирдлага болон бусад нэгж, үйл ажиллагаанаас хараат бус байдаг ба ажлаа ТУЗ, Аудитын хороонд тайлагнаж, аудитлагдсан нэгж, үйл ажиллагаатай холбоотой тайланг Гүйцэтгэх удирдлагад мэдээлж, шаардлагатай сайжруулах ажлуудыг цаг тухайд нь хийлгэдэг.

Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан арга, аргачлалын үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд ТУЗ-өөс баталсан аудитын төлөвлөгөөний дагуу баталгаажуулалт хийж, банкны дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулах, гарсан алдаа, дутагдлыг засах, үйл ажиллагааг сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлага болон газар, нэгжид мэргэжлийн зөвлөмж өгч ажиллаж байна.

Тайлант 2024 он нь Дотоод аудитын газрын хувьд дараах онцлог бүхий жил байлаа. Үүнд:

1. Дотоод аудит, дотоод хяналтын автомат системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.
2. Шүгэл үлээх суваг, дотоод аудитын мэдээлэл хүргэх дотоод вэб сайтыг нэвтрүүлэв.
3. Банкны хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох аргачлал, стандарт, тооцооллыг автоматжуулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэв.
4. Дотоод ажил, аудитын аргачлал, үйл ажиллагааны автоматжуулалтыг сайжруулав.
5. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд аудитын тайлангуудыг танилцуулж, Дотоод аудитын газраас гаргасан санал, дүгнэлт, үнэлгээ, зөвлөмжийн гүйцэтгэлийг тухай бүр авч хэлэлцэн, бүхий л шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.



 **ЭРСДЭЛИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН ГАЗАР
ГАЗАР ХЭЛТЭС**

Эрсдэлийн удирдлага	
Эрсдэлийн удирдлага	
Эрсдэлийн хяналт	
Эрсдэлийн хяналт	
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	
Зээлийн эрсдэл	

БҮЛЭГ АЖИЛ	
ОУ-н стандартын хөрвөх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтүүдийн тооцоолол - ICAAP/ILAAP & Recovery plan	
Чанаргүй активыг бууруулах төлөвлөгөөг 113% давуулан биелүүлсэн – more than 100% of performance of NPL strategy	
Банкны дотоод хяналтын тогтолцоог сайжруулан эрсдэлийн хяналтын хэлтэстэй болсон	
Хяналт болон эрсдлийн дохио	
JIRA system шинэчлэсэн	
Зээлийн эрсдэлийн удирдлага	

ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

Базелийн стандартад заасны дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г дотооддоо үнэлэх аргачлалыг холбогдох журмын дагуу тооцож, макро стресс тест хийж, богино хугацааны бизнес загварыг үнэлсэн.
Чанаргүй зээлдэгчид шаардлагатай арга хэмжээг авч ажилласнаар нийт 3.8 тэрбум төгрөгийг мөнгөөр төлүүлж, ББГ-тай хамтран 825 сая төгрөгийн ӨБХ-өөр зээл төлүүлж, холбогдох зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 8%-аас хэтрүүлэхгүй буюу 4.6%-д барьж хянаж ажилласан. 2.2 тэрбум төгрөгийн зээлийн төлүүлэхэд шүүхийн байгууллага, харилцагчийн эвлэрлийн процессыг амжилттай гүйцэтгэсэн. Чанаргүй зээлийн багцыг 3.99%-ийн эрсдэлийн аппетитын мэдэгдэлд барьж ажиллахаас улирал бүр 3.98%, 3.56%, 3.5% болгон бууруулж ажиллаж байна.
Банкны дотоод хяналт, эрсдэлийн хяналтын тогтолцоог сайжруулан Банкны бүхий л үйл ажиллагааг хянах, тайлагнах чиг үүрэг бүхий хяналтын нэгжтэй болсон.
1. Эх үүсвэр барьцаалсан зээлийн хяналт /2043 зээлийн барьцаа холбоогүй 46 зээлийн 1.7 тэрбум төгрөг, Иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй этгээдэд олгосон 22 зээлүүдийг илрүүлэн залруулсан/ 2. Шуурхай зээлийн хяналт /1354 зээлийн скорингтой харьцуулсан шинжилгээ, чанаргүй болж буй шалтгаан хариу арга хэмжээг тодорхойлсон/ 3. Банкны түүхэн хугацааны чанаргүй зээлийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. /Хугацаа, нас, сектор, бүтээгдэхүүн, салбар зэргээр шинжилгээ хийсэн ба 2018-2024 оны хооронд 1 их наяд гаран төгрөгийн зээл олгосноос 25 тэрбум төгрөг нь чанаргүй ангилалд шилжин хаагдсанаас үүнээс байгууллагын зээлүүд хамгийн өндөр хувьтай чанаргүй болж байсан. Иргэний хувьд 49-56 настай иргэд чанаргүй болж байсан./ 4. Олголтын хяналтын модель боловсруулж эхэлсэн. 5. Хүү шимтгэлийн ерөнхий нөхцлийн хяналт. 6. Нэгж зээлийн хяналтаар: - Зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрээс 945 зөрчил - Зээлийн хяналтаар 193 зөрчил илрүүлсэн байна.
Jira system-ийн банканд ашиглах боломжийг бий болгож бодитоор 200,000 USD хэмнэж байгаа Зорилтод хэрэглэгчдэд мэдээллийг хүргэх, хэрэгжилтийг хянах, тайлагнах зорилгоор Банкны удирдлагын мэдээллийн системд Jira системийн SCRUM board хөгжүүлж, Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороодод нэвтрүүлж, холбогдох ажиллагчдыг сургалт мэдээллээр ханган ажиллаж байна.
2024 онд 696 зээлийн санал хянаж, 109 тэрбум төгрөгийн зээлд эрсдэлийн дүгнэлт бичиж, нэгж зээлийн эрсдэлийг удирдаж ажилласан 2024 онд 20 ажилтны 2.7 т.т-ийн Ипотекийн зээлийг судлаж, шийдвэрлүүлж, ажилтны нийгмийн асуудлыг дэмжиж ажилласан

ТООН ҮР ДҮН

ОУ-н стандартын дагуу бизнесийн загварыг үнэлж, дэлхийн түвшиний меннежменттэй болох боломжийг бүрдүүлсэн.
ОУ-н стандартын дагуу бизнесийн загварыг үнэлж, дэлхийн түвшиний меннежменттэй болох боломжийг бүрдүүлсэн. 3.8 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг мөнгөөр төлүүлж
Зээлийн үйл ажиллагааг бүтээгдэхүүн, салбарын тоон болон нэгж хяналтаар хянаж зөрчлүүдийг арилгав
Банкинд учирч болох эдийн болон эдийн бус эрсдэлийг бууруулсан. Зөвхөн олгосон зээлийн зайны хяналтаар 13 тэрбум төгрөгийн 1535 ширхэг зээл хянагдсан.
200,000 USD
111.7 т.т-ийн зээлийн хүсэлт шийдвэрлэсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

1. Ажлын байрны зураглалыг нийт 110 ажлын байранд хийсэн
2. Ажилтны цалин нэмэгдлийг 2024 оны 8-р сард хийсэн ба салбарын ажилтнуудын цалинг хамгийн их буюу 33 хүртэл хувиар нэмэгдүүлсэн
3. Салбарын борлуулалтын ажилтнуудын сар бүрийн KPI үнэлгээг Tableau тайлангийн системд автоматжуулсан
4. Жира систем service desk-ээр бүх төрлийн хүсэлт зөвшөөрөл шийдвэрлэх үйл ажиллагааг нэвтрүүлэв.
5. Оргил салбар хөрөнгө оруулалтын төсвийн дагуу засвар тохижилтын ажлыг гүйцэтгэж ашиглалтанд оруулсан.
6. Банкны 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг амжилттай зохион байгуулж ажилласан

ХҮНИЙ НӨӨЦ




БАКАЛАВР
80%



МАГИСТР
10%




ДОКТОР
2%



 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

QR ашиглан хийсэн гүйлгээг Монгол улсын стандарт нийцүүлэн гүйлгээний төрлөөр ангилан Монгол банкны төлбөр тооцооны нэгдсэн системд нийлүүлэх боломжтой болсон.
Бага дүнт, АСН+ Багц гүйлгээ, САМ дансны нэгдсэн сан Монгол банкны төлбөр тооцооны системийн өргөтгөл шинэчлэлийн ажилд хамтран амжилттай шилжүүлсэн.
Монгол банкны их өгөгдөл, BIGDATA төслийн эхлэл болж өгөгдлийн шууд холболт дэд бүтэц бий болгох, үндсэн мэдээлэл, зээл болон барьцаатай холбоотой 11 хүснэгт өгөгдөл мэдээллийг амжилттай нийлүүлсэн.
Монгол банкны нэгдсэн дансны дугааралт олон улсын стандартад шилжих ажлын хүрээн IBAN дансны дугаарлалттай холбоотой цахим банк, үндсэн системд хөгжүүлэлт хийсэн.
Tableau dashboard хөгжүүлэлт санхүү тайлан, зээл, салбарын KPI, хүний нөөцтэй холбоотой хөгжүүлэлтийг холбогдох нэгжүүдтэй хамтран хийгдсэн.
NES үндсэн системийн app server-н windows server системийг LINUX амжилттай шилжүүлж, windows системийн Licence төлбөр бууруулах, систеийн хурд, ачаалал даах чадавхи, аюулгүй байдлыг тус тус нэмэгдүүлэв.
Зээл худалдан үйлдэлтэй холбоотой үүрэгтэй худалдсан зээлүүдийн Татварын НӨАТ-н баримт давхардуулахгүй байх ажил хийгдсэн.
Монгол банк-аас шинэчлэн зөвшөөрсний дагуу “Харилцагч зайнаас бүртгэх” шийдлийг сайжруулан нэвтрүүлээд байна. Одоогоор 14226 харилцагч зайнаас бүртгээд байна. Шинэ харилцагч эх үүсгэвэр 424,317,324.02 Үлдэгдэлтэй, 738 удаагийн 4,391,636,121.34 зээлийн үйлчилгээ авсан байна.
Agent бүртгэл буюу Даатгал болон Богд Лизинг харилцагч бүртгэх боломжтой болж 966 харилцагч хялбаршуулсан хэлбэрт бүргэсэн байна.
Шуурхай зээл 2 нэвтрүүлж, 4760 удаагийн 4’508’900’000 төгрөгийн олголт хийж 67’636’700 шимтгэл орлого, 204’501’744.01 хүүний төлбөр олоод байна.
Card cashback – маргааш өдөр нь харилцагчид буцаан олголт олгох үйлчилгээ нэвтрүүлсэн
Emongolia-аас мэдээлэл аван скоринг хийх үйлчилгээг хялбаршуулсан
Bogd mobile ажилтаны булан хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн /ирц, судалгаа, хандив, ажилчид, үндсэн хөрөнгө, ээлжийн амралт/
Bogd mobile файл хэсэгт гэрээ, ebarimt бүртгэл, лавлагаа хадгалах cloud үйлчилгээ нэвтрүүлсэн.
Bogd mobile custom notification, ebarimt хялбар бүртгэл, дансны тусгай нууцлал, харилцагчийн гүйлгээний баталгаажуулалт аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.
ДАГ хамтран зайнаас авто хяналт хийх систем 40 гаруй дүрэмээр шалган анхааруулга хүргэх боломж бүрдүүлээ. Комплайнс хэлтэстэй хамтран үндсэн системийн хандалтыг хянах зайн шийдэл
New.Bogdbank.com интернэт банкны v3 хувилбарын нэвтрүүлэх ажил эхлүүлээд байна.

Монгол банк тоо мэдээ, тайлан илгээхтэй холбоотой 5 томоохон тайланг outsourcing хийж, нэгжүүдтэй хамтран үндсэн системийн 33 тайлан шинээр хөгжүүлэн, 14 тайланг нэмэлт хөгжүүлэлт ССХ-д хийлээ.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

tapa

Tarapir байгууллагатай хамтран скүүтер болон унадаг дугуйны төлбөрийг Богд банкны дансаар цэнэглсэн харилцагчдад 100%-ийн буцаан олголттой урамшуулалт аяныг хэрэгжүүлсэн.

1-P CAP

2-P CAP

3-P CAP

4-P CAP

5-P CAP

6-P CAP

Хүүхдийн мөнгөн тэтгэмжээ холбосон харилцагчдад "Буцаан олголт" олгох урамшуулалт аян.

Банкны салбарт ирэхгүйгээр "Bogd Mobile" апп-р дамжуулан харилцагч болох боломжтой болсон.



Харилцагчийн өдөр тутмын гүйлгээг дэмжих зорилгоор нийт харилцагчийн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данс хөтөлсний хураамжийг хөнгөлсөн.

Харилцагчийн өдөр тутмын гүйлгээг дэмжих зорилгоор нийт харилцагчийн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данс хөтөлсний хураамжийг хөнгөлсөн.

Шинэ "Оргил" салбарын нээлтийн үйл ажиллагаанд зориулан тус салбараас үйлчилгээ авсан харилцагчдадаа зориулж бүтээгдэхүүн, үйлчилгээний хөнгөлөлт, урамшуулалт аяныг амжилттай хэрэгжүүлсэн.

7-P CAP

8-P CAP

9-P CAP

10-P CAP

11-P CAP

12-P CAP

UnionPay карттай харилцагчдад зориулан БНХАУ-ын нутаг дэвсгэрт Богд банкны картаараа гүйлгээ хийсэн харилцагчдад буцаан олголт урамшуулалт аяныг хэрэгжүүлсэн.



Mobile Legends: Bang Bang картыг зах зээлд нэвтрүүлсэн.



ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

БОГД БАНК нь иргэдийн харилцагчдадаа зориулж харилцагчийн хэрэгцээ шаардлагад зориулсан бүхий л төрлийн нөхцөлтэй уян хатан харилцах болон хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлсээр ирсэн билээ. Бид уламжлалт харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн хөгжүүлэхээс гадна хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын мэдлэгийг дээшлүүлэх зорилгын хүрээнд санхүүгийн хэрэглээ болон СОНИРХОЛ-д нь нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг жил бүр цоо шинээр нэвтрүүлсээр байгаа билээ. Тайлант онд бид хүүхэд, залуучууддаа зориулан дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүллээ. Үүнд:

1. 2024 оноос хэрэгжиж байгаа “Хүүхэд бүрт 100,000 төгрөгийн хадгаламжийн эрх” урамшуулалт аяныг 2025 ондоо мөн үргэлжлүүлэн хэрэгжүүлж амжилттай дуусгасан.
2. Монгол Улсаас нийт хүүхэд багачуудад олгодог 100,000 төгрөгийн Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхдийн хадгаламждаа хийж, хуримтлалтай болохыг уриалан “Хүүхдийн мөнгөн тэтгэмжээ хадгаламждаа хүлээн авсан харилцагч буцаан олголттой” урамшуулалт аяныг зохион байгуулсан.
3. Хүүхэд багачуудын ИРЭЭДҮЙН ХУРИМТЛАЛЫГ ДЭМЖИХ зорилгоор Хүүхдийн хадгаламждаа орлого хийсэн Хүүхэд бүрд ТОГЛООМЫН ТӨВ-д тоглох эрхийн бичгийг бэлэглэсэн.
4. Бид Mobile Legends: Bang Bang компантай хамтран хүүхдэд зориулсан төлбөрийн картыг нэвтрүүлсэн ба ХУРИМТЛАЛЫГ ДЭМЖИХ зорилгоор хүүхдийн хадгаламж эзэмшдэг хүүхдэд олон нийтэд зарлаагүй тусгай баатрын зурагтай загварыг санал болгож байна.
5. БОГД БАНК нь хүүхэд багачуудын санхүүгийн хэрэглээнд зориулан ХҮҮХДИЙН БАГЦ бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож эхэлсэн. Багц үйлчилгээнд өрсөлдөхүйц өндөр хүүтэй хүүхдийн хадгаламжийн бүтээгдэхүүн, эцэг эх нь хүүхдийн хадгаламж руугаа шилжүүлэг хийхэд 0 төгрөгийн шимтгэлтэй нөхцөл болон хүүхдийн карт үнэгүй олгох гэсэн хөнгөлөлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг багц болгон нэвтрүүлсэн.
6. Банк нь дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тайлант онд Богд банкаар хүүхдийн мөнгөн тэтгэмжээ хүлээн авсан харилцагчийн тоо өмнөх оны мөн үеэс 30.2%-иар, нийт хүүхдийн хадгаламжийн тоо 26.6%-иар тус тус өссөн байна.

“ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР-2024”

БОГД БАНК нь жил бүр Монголбанк, ХДК, МБХ болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулдаг “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийн аянд идэвхтэй оролцдог билээ. Бид тайлант оны “Дэлхийн Хуримтлалын Өдөр-2024” аяны хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалын соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр олон арга хэмжээг амжилттай зохион байгуулан нийт арилжааны Банкууд дундаас 3 дугаар байранд орлоо. Уг аян нь залуучууд болон хүүхдүүдийн санхүүгийн мэдлэгээ нэмэгдүүлэх, хуримтлалын ач холбогдлыг ойлгох боломжийг олгодог бөгөөд энэ хүрээнд Банк нь олон нийтэд чиглэсэн боловсролын хөтөлбөр, урамшуулал, инновацлаг бүтээгдэхүүнийг нэвтрүүлсээр байх болно.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдах шинэ тоног төхөөрөмж, машин механизмыг худалдан авахад зориулсан техник тоног төхөөрөмжийн зээл, орон сууц худалдан авахад шаардлагатай урьдчилгаа төлбөрийг санхүүжүүлэхэд зориулсан орон сууцны урьдчилгаа төлбөрийн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлсэн. Мөн эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээл, КҮБ-ын орлого барьцаалсан зээл зэрэг бизнесийн зээлийн хугацааг уртасгаж, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийг уян хатан болгож тэдэнд олгох санхүүжилтийг нэмэгдүүлж үйл ажиллагааг нь дэмжин ажиллалаа.

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

БОГД БАНК нь харилцагчийн хэрэгцээнд нийцсэн дэлхийн аль ч улсад төлбөр тооцоогоо саадгүй гүйцэтгэх боломжтой Олон Улсын Виза, ЮнионПэй болон Монгол Улсын Т брэндийн нийт 8 төрлийн төлбөрийн картын бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож байна. Бид жил бүр харилцагчийн сонирхол, хэрэглээнд нийцсэн цоо шинэ картын бүтээгдэхүүнийг нэвтрүүлдэг ба бид тайлант хугацаанд Цахим спорт сонирхогч хүүхэд, залууст зориулан дэлхийн 47 оронд 1-рт жагсдаг, 1 тэрбум гаруй хэрэглэгчтэй цахим тоглоом болох Mobile legends: Bang Bang тоглоомын компанитай хамтран Mobile legends: Bang Bang тоглоом дахь баатрын зурагтай картын бүтээгдэхүүнийг албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлсэн. БИД энэхүү картыг захиалсан харилцагчдадаа тус тоглоомд ашиглах Diamond-н урамшууллыг бэлэглэхээс гадна олон төрлийн урамшуулалт аянуудыг хэрэгжүүлсээр байна.

БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАГЧДАД ЗОРИУЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

БИД байгууллагын харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүхий л төрлийн харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байгаа билээ. Банк нь байгууллагын санхүүгийн хэрэгцээнд зориулан өндөр хүүгийн өгөөж тооцох боломжтой шаталсан хүүт харилцах дансны үйлчилгээ болон хугацаа дуусахаас өмнө буюу хугацааны дундуур зарлага гаргах эрхтэй Смарт хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүний тус тус санал болгож байна.

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Жижиг дунд бизнес эрхлэгч болон байгууллагын харилцагчдадаа зориулж аялал жуулчлалын салбарыг дэмжих төслийн зээл, хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл, хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжих хөрөнгө оруулалт зээл, Засгийн газраас хэрэгжүүлж буй ноолуур бэлтгэлийн зээл, хоршооны гишүүн малчны зээл зэрэг бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж ажиллалаа. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор бизнесийн зээлийн хугацааг уртасгаж, Монгол банк, Зээлийн батлан даалтын сан, ХХААХҮЯм зэрэг байгууллагатай хөнгөлөлттэй хүүтэй зээлийн бүтээгдэхүүнээр хамтран ажиллалаа.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчдынхаа санхүүгийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Бодь Даатгал, Монре Даатгал, Монгол Даатгал, Мандал Даатгал зэрэг даатгалын салбарын тэргүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцагчдадаа өргөн хүрээний даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож ажилладаг билээ. Тайлант онд нийт 2189 харилцагчийн 229.4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг даатгалын зуучлалын үйлчилгээгээр дамжуулан даатгалд хамруулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 5.6%-ын өсөлттэй ажиллаа. Бид даатгалын зуучлалын үйлчилгээгээ харилцагчдадаа илүү хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор дотоод үйл ажиллагаагаа цахимжуулж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулан ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОН БОГД БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ТОС-ын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн ажил. Үүнд:

Байгаль, орчноо хамгаалах (Нөөцийн хэмнэлт ба экосистемийг хамгаалах үйл ажиллагаа)

БОГД БАНК нь жил бүр нөөцийн хэмнэлтийн шинэ санаачилгуудыг хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй бодлого баримталж ирсэн билээ. Бид тайлант хугацаанд дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- Цаасны хэмнэлтийн хүрээнд харилцагч салбарт ирэхгүйгээр Банкны Bogd Mobile апп-р дамжуулан харилцагчаар бүртгүүлэх боломжийг нэвтрүүлсэн. Энэхүү хэмнэлтийг хэрэгжүүлснээр нэгж харилцагч бүрд хэвлэж байсан 5 хуудас бүхий маягт, гэрээг хэвлэхгүйгээр цахим байдлаар хүргүүлэх боломжтой болж цаасны хэмнэлтийг хийлээ.
- Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллаж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлсэн бөгөөд ашиглалтаас гарсан батарейгаа байгальд ээлтэй технологиор устгуулан, байгаль орчноо хайрлан хамгаалах үүргээ биелүүлж эхэлсэн.
- Олон нийтэд зориулан "Байгаль орчноо хайрлан хамгаалах", "Усны хэмнэлт"-тэй холбоотой уриалга бүхий мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.
- Тайлант хугацаанд харилцагчдадаа бэлэглэх гарын бэлгэнд "Эко аяга" буюу олон удаагийн хэрэглээний аягыг сонгон бэлэглэж, нэг удаагийн хуванцар хэрэглээг бууруулахад хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих

БОГД БАНК нь тайлант хугацаанд ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих үүднээс Олон Улсын санхүүгийн байгууллага Triple Jump/Gender Global Smart Fund болон Азийн Хөгжлийн Банкаас тус тус "Ногоон" тодорхойлолттой зээл, Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийг санхүүжүүлэх зорилгоор санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.

Санхүүгийн хүртээмжийг дэмжих

БОГД БАНК нь нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлж байна:

- Цахилгаан автомашиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, 16,111.2 кг хүлэмжийн хийн ялгарлыг хэмнэх боломжтой болов.
- Автомашин тус бүрийн ялгарлын тооцоолол хийж, шатахуун зарцуулалтын хяналтыг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- Харилцагчдадаа "НОГООН" тодорхойлолттой дараах зээлийн бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэн санхүүжилтийг түлхүү олгож байна.
 - Ногоон хэрэглээний зээл
 - ЭКО автомашины зээл
 - "Дулаан шийдэл" төслөөр Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн сууцандаа дулаалга хийлгэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зээл
 - Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан зээл

Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Банк нь Олон Улсын хөрөнгө оруулалтын сангаас байгаль орчинд ээлтэй болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг санхүүжүүлэх зорилгоор татсан санхүүжилттэй холбоотой бүхий л төрлийн тайлан мэдээллийг Олон Улсын байгууллагад тухай бүр хүргэн ажиллаж байна. Мөн БИД улирал болон жил бүрийн Банкны тайландаа Тогтвортой санхүүжилттэй холбоотой ажлын тайланг ил тод танилцуулан ажиллаж байна.

Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Богд Банк нь нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийг хамарсан боловсрол, бизнесийг дэмжих болон эрүүл амьдралын хэв маягийг дэмжих сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Банк нь нийт ажиллагсдадаа "Иргэн бүрт Эрүүл мэнд уриан дор" гэсэн сэдэв бүхий ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал сургалтыг зохион байгууллаа.
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөжүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмжийг сайжруулж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бизнесийн үйл ажиллагаанд тохирсон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах сургалтыг зохион байгууллаа.

Үлгэрлэн манлайлах

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Банк нь "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдсэн ба жил бүр тарьсан модоо услах, нөхөн сэргээх ажлыг тогтмол зохион байгуулж байна. Мөн БИД МБХ, Монголбанк болон бусад арилжааны Банкуудтай хамтран 14 га газарт 1000 гаруй мод нэмж тарьсан.
- "Намрын мод тарих өдөр" арга хэмжээг бусад Банкны салбарынхантай хамтдаа зохион байгуулсан ба намрын тарилтаар бид нийт 6,000 ширхэг навчит болон шилмүүст мод тарьснаас гадна 1,000 гаруй шилмүүст мод нэмж тарьсан.
- Их хотын түгжрэлийг бууруулах зорилгоор ухаалаг, байгальд ээлтэй шийдлүүдийг дэмжин ажиллав. Энэ хүрээнд "Тара" эко унаа – унадаг дугуй, скүүтер түрээслэх үйлчилгээг дэмжиж, харилцагчид Bogd Bank-ны Bogd Mobile апп ашиглан хэтэвчээ цэнэглэснээр түрээсийн төлбөрийн 100%-ийг буцаан авах боломжийг бүрдүүлэв.



 БИЗНЕС БАНКНЫ ГАЗАР

Онцлох ажил

Зээлийн багц

Эх үүсвэр

Ашиг

Шинэ салбар

Хөрөнгө борлуулалт

Багцын чанар

Зээлийн судалгаа

Зээл төлүүлэх үйл ажиллагаа

ТАХ

Харилцагчийн тоо

ПОС

Карт

Тайлбар

Зээл болон эх үүсвэргүй баталгааны багцыг өмнөх оноос 178.3 тэрбумаар цэвэр өсгөж, 435.5 тэрбумд хүргэж, төлөвлөгөөгөө давуулан биелүүлэв. 6889 харилцагчид 588.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Эх үүсвэрээ 92.9 тэрбум төгрөгөөр цэвэр өсгөж, иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг 403.8 тэрбум хүргэв.

Салбарын ашиг өмнөх жилээс 133% өсч 28.6 тэрбумд хүрэв

Шинээр Прайм, Оргил, Ривер салбарыг нээв. Цаашид эх үүсвэрт төвлөрсөн Прайм салбаруудыг нэмэгдүүлэх бөгөөд хариуцсан Хувийн банкны хэлтсийг байгуулав.

112 ширхэг өмчлөх бус ҮХХ-г 47.8 тэрбум төгрөгөөр борлуулж, банкинд 4.76 тэрбум төгрөгийн олз оруулав.

Нийт салбаруудын зээлийн багцад эзлэх анхаарал хандуулах зээлийг 10.7% - 6.7%, чанаргүй зээлийг 3.7%- 3.0% болгож буурууллаа.

280 зээлийн 229.8 тэрбум төгрөгийн зээл судалгааг хийж, 170.6 тэрбум төгрөгийн олголт хийв

Давхардсан тоогоор 10962 зээлдэгчтэй 32500 удаагийн дуудлага хийж, 110 мэдэгдэл хаягаар хүргэж өгсөн. 12.9 тэрбум төгрөгийн зээл төлүүлж, нэмэгдэх байсан 33.8 тэрбум төгрөгийн сангийн зардлыг буцаасан

Нийт 241 зээлийг төлүүлэхээр хариуцан ажиллахдаа 8,1 тэрбумын төлөлт хийлгэж, 3.4 тэрбум төгрөгийн сан, 1.9 тэрбум төгрөгийн балансын гадуур хүү буцааж, банкны ашигт 5,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн

Салбар нийт 15685 харилцагч шинээр бүртгэв.

Өнгөрсөн жилээс 127%-р илүү ПОС борлуулж, нийт 2676 КҮБ-тай болов.

Өнгөрсөн жилээс 112%-р илүү карт борлуулж, нийт 34 мянга гаруй карт эзэмшигчтэй болов.



БАЙГУУЛЛАГЫН БАНК

1. Эх үүсвэр /хадгаламж/

Нийт харилцах оны эцэсээр - **1,2 тэрбум** болсноор Нийтэх үүсвэр **21,5 тэрбум төгрөг** болов.

Нийт арилжааны дүн: **7,1 тэрбум төгрөг**

Нийт зээлийн дүн: **4,8 тэрбум төгрөг**

2. Жижиг дунд үйлдвэрийн газартай хамтран нийт 80 гаруй аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудтай семинар зохион байгуулав.

ГАДААД ХАРИЛЦАА

1. EMF Microfinance Fund (EQ) болон GGSF (Triple Jump) байгууллагуудаас амжилттайгаар нийт 14 сая ам.долларын санхүүжилтийг татсан.

2024 онд EMF Microfinance Fund (EQ)-тэй дөрөв болон тав дахь санхүүжилтийн гэрээг байгуулан, ЖДҮ дэмжих 9 сая ам.долларын санхүүжилтийг, GGSF (Triple Jump)-тай анхны санхүүжилтийн гэрээг байгуулан, эмэгтэй ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн 5 сая ам.долларын санхүүжилтийг тус тус татан банкны нийт активыг 48 тэрбум орчим төгрөгөөр өсгөсөн.

2. ADB-ээс 15 сая ам.долларын санхүүжилтийг амжилттайгаар татсан

Азийн Хөгжлийн Банктай (ADB) 2024 оны 6 сарын 27-нд санхүүжилтийн гэрээг байгуулан, 15 сая ам.долларын ЖДҮ тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгч болон ногоон зээл дэмжих санхүүжилтийг татан банкны нийт активыг 51 тэрбум орчим төгрөгөөр өсгөсөн.

3. FMO-той амжилттайгаар 20 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг байгуулаа

FMO-тай харилцааг эхлүүлэн, магадлан шалгалтыг (due diligence) амжилттай давж, 2024 оны 12 сарын 11-ны өдөр анхны 20 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг байгуулан. Энэхүү санхүүжилт нь хөдөө аж ахуй, эмэгтэйчүүд, залуучуудын ЖДҮ болон ногоон төслүүдэд чиглэсэн байна.



ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Олон улсын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч StoneX байгууллагатай Global master repo agreement (GMRA) гэрээг байгуулж 15 сая ам.долларын репо арилжааны шугам батлуулснаар банкны болон харилцагчийн нэрийн өмнөөс үнэт цаас барьцаалсан санхүүжилтийг татах боломжтой болсон.

2. 2024 онд нийт 42.6 сая ам.долларын урт хугацаат своп хэлцэл хийснээр харилцагчийн болон банкны өөрийн гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийг валютын ханшийн эрсдлээс бүрэн хамгаалж чадсан.

3. 2024 онд гадаад зах зээл дэх үнэт цаасны арилжааг идэвхижүүлж, оновчтой хөрөнгө оруулалтыг хийснээр зөвхөн үнэт цаасны арилжаагаар 2.8 тэрбум төгрөгийн цэвэр ашиг /2024 оны 11 сарын байдлаар/ хүртсэн ба энэ нь өмнөх жилээс 6.6 дахин өссөн үзүүлэлт юм.

КОМПЛЕЙНС


“Банк холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартад нийцүүлэн ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулж, бизнесийн болон ажилтны ёс зүйг эрхэмлэсэн шударга ёс, ил тод байдал, нэр хүндийг хамгаалахад чиглэсэн Банкны ТУЗ - өөс баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг, банкны бүхий л түвшинд мөрдөж ажиллах Комплайнсын бодлогын баримт бичгийг шинээр батлуулсан.”



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ

Нийт хөрөнгийн дундаж өсөлт 2017 оноос - 46%




ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

Зээлийн үлдэгдлийн дундаж өсөлт 2017 оноос - 87%




ХҮҮНИЙ ОРЛОГО

Хүүний орлогын дундаж өсөлт 2017 оноос - 55%




ЦЭВЭР АШИГ

Хүүний орлогын дундаж өсөлт 2017 оноос - 66%




НИЙТ ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн дундаж өсөлт 2017 оноос - 52%




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Өөрийн хөрөнгийн дундаж өсөлт 2017 оноос - 30%




ХҮҮНИЙ ЗАРДАЛ

Хүүний зардлын дундаж өсөлт 2017 оноос - 86%




ХАРИЛЦАХ ХАДГАЛАМЖ


Хүүний орлогын дундаж өсөлт 2017 оноос - 66%



ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ



ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА



Санхүүгийн голлох үзүүлэлтүүд:

- Нийт хөрөнгө 2024.12.31-ний байдлаар 1,062,581.67 сая төгрөгт/1 их наяд 62 сая төгрөгт/хүрч өмнөх жилээс 49.17%-аар өссөн байна.
- 2024 оны цэвэр ашиг 40.2 тэрбумд хүрч өмнөх оноос 42.5%-аар өссөн ба өнгөрсөн 5 жилийн дундаж өсөлт 48%-тай байна.
- Өөрийн хөрөнгө 169.11 тэрбум төгрөгт хүрч 2014 онд анх байгуулагдсан үеийн 16.07 тэрбум хэмжээнээс 11 дахин өссөн байна.
- Цэвэр зээлийн багц 2024.12.31 гэхэд 577.21 тэрбумд хүрч өмнөх жилээс 84.91%-аар өссөн байна.
- Нийт эээлд эзлэх чанаргүй зээлийн хувь буурч 2.26% -тай болсон байна.
- Харилцах хадгаламж өмнөх оноос 25.19%-аар өсөж 453.82 тэрбум төгрөгт хүрчээ.
- 2024 онд олон улсын банк болон санхүүгийн байгууллагаас нийт 49.07 сая ам долларын урт хугацаат эх үүсвэр шинээр татан төвлөрүүлж, жижиг дунд бизнесийг тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагаа болон хэрэглээг санхүүжүүлэхэд зориулахаар ажиллаж байна.
- Тайлант хугацаанд Богд банк нь Банкны тухай хуулиар болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа. Үүнд:
 - Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 21.20% (байвал зохих хэмжээ 12.5%). Ийнхүү давуулан биелүүлсэн нөөц өөрийн хөрөнгө нь аливаа болзошгүй эрсдэлийг даахаас гадна ирээдүйд активын тэлэлт хийх, ногдол ашиг тараах боломжийг бий болгодог.
 - Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 30% (байвал зохих хэмжээ 25.0%) буюу бусдаас татан төвлөрүүлсэн нийт эх үүсвэрийнхээ 31% болох 228.47 тэрбум төгрөгийг бэлэн мөнгө болон бэлэн мөнгөнд түргэн хөрвөх боломжтой Монголбанкны Үнэт цаасанд байршуулан удирдаж байна.



БОГД БАНК



Богд цамхаг, Жигжиджавын гудамж,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199
Факс: +976 11 328311
Вэб: www.bogdbank.com
И-мэйл: info@bogdbank.com